

С.Батбуян. Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол Улсын хууль

**Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай
Монгол улсын хууль**

*Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн
сургуулийн эрх зүйн 5 дугаар
ангийн оюутан С.Батбуян*

Агуулга

1. Төрийн мэдээллийн ил тод байдлын зарчим болох иргэний мэдэх эрхийн суурь, үндэс
2. Мэдэх эрхийг хуулиар баталгаажуулах шаардлага ба Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай Монгол улсын хуулийн эрэмбэ
3. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарах байгууллагууд
4. Нээлттэй, ил тод байх мэдээллийн тухай

1. ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЗАРЧИМ БОЛОХ ИРГЭНИЙ МЭДЭХ ЭРХИЙН СУУРЬ, ҮНДЭС

Нэг. Мэдээллийн ил тод байдлыг хангах нь төрийн үндсэн үүрэг болох тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заажээ. Ардчилсан ёсны зарчим нь ард түмний засаглах бүрэн эрх гэсэн утгыг илэрхийлж, ард түмний засаглах бүрэн эрхийг хангаж, зохион байгуулахыг үндсэн арга замаа болдог. Ардчилсан зарчимд засаглах эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ард түмэн сонгох, үйл ажиллагаанд нь оролцох, хяналт тавих, олон намын тогтолцоо, олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хангах, хэвлэлийн эрх чөлөөг хүндэтгэх, олны санаа бодол, гаргасан шийдвэр зэрэгт тулгуур ач холбогдол өгөх зэрэг олон элементээр хэлбэршин илэрдэг¹. Товчоор бол хүмүүс өөрсдөд нь нөлөөлөх аливаа шийдвэрийг гаргахад оролцох ёстой. Тийм учраас ардчиллыг сонгосон улс орны хувьд төрийн зүгээс мэдээллийн ил тод байдлыг хангах нь ардчиллыг бэхжүүлэх чухал арга зам болох бөгөөд түүнчлэн тухайн төрийн үндсэн үүрэг болно. Ардчиллыг хэрэгжүүлж буй этгээдийн үйл ажиллагаа нь ил тод байснаар иргэн хяналт тавьж, шаардлага гаргах суурь болно. Нөгөө талаас ил тод байдал хангагдсанаар иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэж, төрийн бодлого шийдвэрийг дэмжих, оролцох идэвхи нэмэгдэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд үр дүнтэй ахиц гардаг байна.

Хоёр. Үндсэн хуулиар баталгаажсан Мэдэх эрх.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал² /ХЭТТ/-ын 19 дүгээр зүйл, Монгол Улс 1974 онд нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын факт³ (ИУТЭОУФ)-ын 19 дүгээр зүйлд⁴ “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсвэл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсвэл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх, эрх чөлөө багтана” гэж зааснаар Монгол улс иргэний мэдэх эрхийг хангах баталгаажуулах үүргийг Олон улсын өмнө хүлээсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх

¹ Хамтын бүтээл. “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ.,2009.

² НҮБ-ын Ерөнхий Асамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны 217 (III) тогтоол.

³ Төрийн мэдээлэл сэтгүүл. Тусгай дугаар: Боть I. УБ.,2004.

С.Батбуян. Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол Улсын хууль

эрхтэй; 16 дахь хэсэгт итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй; 17 дахь хэсэгт төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж тус тус заажээ.

Харин Олон улсын хүний эрхийн баримт бичигт зааснаар “мэдэх эрх” нь мэдээллийг хайх, хүлээн авах, түгээх эрхээс бүрдэж байна. Монгол улсын Үндсэн хуульд мэдэх эрхийн төртэй холбогдсон мэдээллийг хайх, хүлээн авах эрхийг баталгаажуулсан бөгөөд нэгэнт хүлээн авсан мэдээллийг түгээх эрх бол иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх болон хэвлэн нийтлэх эрхээр хамгаалагдаж байна. Өөрөөр хэлбэл Олон улсын хандлагаар бол үзэл бодлоо илэрхийлэх эрхийн нэг бүрдэл хэсэг нь мэдэх эрх байх бол МУ-ын хувьд тус бүрт хуульчлан баталгаажуулсан байгаа нь зарчмын хувьд ялгаагүй байна.

Ийнхүү мэдэх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан тул энэ эрхээ хэрэгжүүлэх бүхий л төрлийн нөхцөл, арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг төр хүлээнэ. Энэ эрхийг баталгаажуулсан хэдий ч зарим нэг хуулиудад ил тод байдлыг хангана, нээлттэй байна гэхчлэн зааснаас бус яаж хангах талаар тусгайлсан зохицуулалтгүй явсаар 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (цаашид МИТБМАЭХ гэх)-ийг баталсан байна. Энэ хууль батлагдахаас өмнө Мэдээлэл авах эрхтэй холбоотой хэд хэдэн хуулийн төсөл боловсруулагдаж байсан ба УИХ, Засгийн газраас иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг хангах талаар үндсэн чиглэл, хөтөлбөр зэрэгт тусгаж байсан. Үүний дагуу 2004 онд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдаж, төрийн нууцад хамаарах объектийг тодорхой болгосон нь тухайн нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг тодорхой хэмжээнд эдлэх алхам болж байжээ⁵. Шинээр ардчилалд шилжсэн улсад энэ эрх нь эхэн үедээ захиргаадах дэглэмийн эсрэг шинэчлэлт гэх хандлагатай байсан бол эдүгээ улс орнуудад хүний эрх бөгөөд түүнчлэн хүний үндсэн эрхийг хангах хэрэгсэл гэх үзэл давамгайлах болсон⁶ нь манай улсын хувьд ч хамаарч байна.

2. МЭДЭХ ЭРХИЙГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАХ ШААРДЛАГА БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЭРЭМБЭ

Монгол улс Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Үндсэн хуульд баталгаажсан хүний эрхийг хамгаалах, хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг Үндсэн хуулиараа⁷ хүлээсэн. Энэ үүргийг биелүүлэх нэг чухал арга зам

⁵ “Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц: Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан” УБ., 2011.

⁶ <http://www.unesco.org/new/en/communication-and-information/freedom-of-expression/freedom-of-information/>

⁷ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 19 зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх

С.Батбуян. Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол Улсын хууль

нь тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан, зохицуулагдах асуудлыг бүрэн хамарсан хуулийн батлах, хэрэгжүүлэх юм. Мөн Үндсэн хууль нь хууль болон хуулийг дагалдан гарах актын эрх зүйн эрх зүйн байдал болон эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх зарчмыг мөн агуулдаг нь энэ харилцааг хуульчлан зохицуулахыг шаардаж байна. Харин мэдэх эрхийг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд шинэ Үндсэн хууль баталснаас хойш нэлээдгүй хугацаа өнгөрсний дараа буюу 2011 онд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ыг батласан байна.

Тус хууль зорилгодоо хүрч үйлчлэхийн тулд олон шаардлага, шалгуурыг хангасан байх ёстой бөгөөд юун түрүүнд харилцааг бүхэлд хамарсан байхын зэрэгцээ, хуулийн тодорхой заалтыг яаж, ямар нөхцөлд, хэн, ямар хэмжээнд хэрэглэх, хэрэгжүүлэх вэ, тэгвэл, ингэвэл яах вэ гэдгийг хуулиар нарийн зааж өгөх чухал.

Мөн хууль хэрэглэх, хэрэгжүүлэхэд тус хууль нь эрх зүйн эх сурвалжийн хувьд ямар эрэмбийн хэм хэмжээ болохыг тодорхойлох шаардлагатай байдаг. Харин Монгол улсын хувьд эрх зүйн хэмжээг эрэмбэлэхдээ Үндсэн хууль, Олон Улсын гэрээ, Хууль, Хэм хэмжээний акт гэсэн дараалалтай байхыг Үндсэн хууль болон хуулиудаар тогтоосон боловч адил түвшний эрх зүйн хэм хэмжээг, тухайлбал хуулийг хэрхэн хүчин чадлаар нь эрэмбэлэх нь тодорхойгүй. Онолын хувьд “Тусгайсан зохицуулалт бүхий эрх зүйн эх сурвалж нь ерөнхий зохицуулаттай эх сурвалжийн дээр эрэмблэгдэнэ, Шинээр батлагдсан эрх зүйн эх сурвалж нь хуучин эх сурвалжийн дээр эрэмблэгдэнэ⁸” гэх боловч энэ нь зарчмууд нь шууд хүлээн зөвшөөрөгдөөгүй байна. Ром-Германы эрх зүйн тогтолцоонд хамаарах манай улсын хувьд бүх харилцааг хэм хэмжээгээр зохицуулах тул шинээр батлагдсан хэм хэмжээ нь давуу үйлчлэх, эсвэл өмнө үйлчилж байсан хэм хэмжээ нь шинэ хэм хэмжээтэй уялдан өөрчлөлт, шинэчлэлт хийж байх нь зайлшгүй юм. Гэтэл Мэдэх эрхийн харилцааг зохицуулсан хуулийг 1995 онд батлагдсан Төрийн нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиас бүрдэхээр заасан нь шинэ хуулийн нууцын соёл төлөвшүүлэх, мэдэх эрхийг үндэслэлтэйгээр хязгаарлах нөхцөл бий болох зорилгод харшилж байна. Түүнчлэн шинэ хуультай холбоотойгоор 1995 онд батлагдсан Байгууллагын (угтаа бизнесийн) нууцын тухай хуульд шинэчлэлт, өөрчлөлт оруулаагүй байх бөгөөд энэ хууль нь Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн бүрдэл болохгүй тул шинээр батлагдсан хууль илүү хүчин чадалтай гэж үзэх үндэслэлтэй. Тухайлбал, МИТБМАЭХ-ийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж **ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой**, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг

чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

⁸ П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2008 он.

С.Батбуян. Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол Улсын хууль

учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно” гэж Байгууллагын нууц гэдгийг агуулгын хувьд хувийн эрх зүйн этгээдэд хамаарах бизнесийн нууц гэх хүлээн зөвшөөрөгдсөн утгаар нь тодорхойлсон байна. Гэтэл Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт **“Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой**, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно” гэж заасан төрийн байгууллагын албаны үйл ажиллагаатай холбоотой байгууллагын нууц гэж байж болохыг зөвшөөрсөн нь үндэслэлгүйгээр мэдэх эрхийг хязгаарлах боломжийг бүрдүүлж МИТБМАЭХ-тай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцыг тогтоох, хамгаалах, ашиглах нь зохицуулагдсаар байтал Төрийн байгууллагын нууц гэж тусдаа хуулиар зохицуулагдах үндэслэлгүй.

Тиймээс дээрх тохиолдолд шинээр зарчим, хандлагыг бий болгож буй МИТБМАЭХ нь давуу хүчин чадалтай үйлчилнэ гэж үзнэ. Түүнчлэн ийм тохиолдолд иргэний эрх, ашиг сонирхолд илүү нийцсэн хуулийг дээд эрэмбэтэй гэж үзэх нь төрийн үүрэг гэдгийг анхаарах нь зүйтэй. Үүнээс гадна мэдэх эрхтэй холбоотой харилцааг зохицуулсан олон хууль үйлчилж байгаа бөгөөд тэдгээр нь МИТБМАЭХ-тай зөрчилдөх, тус хуулиар баталгаажсан зарчмыг үгүйсгэсэн зэрэг тохиолдолд тусгай харилцааг зохицуулсан гэдгээр МИТБМАЭХ давуу хүчин чадалтай үйлчлэх эсэх зэрэг асуудал үүснэ. Энэ мэтээр тодорхой зөрчил, маргаан үүсч болзошгүй байх тул хууль хоорондын уялдаа холбоог хангаж, зөрчилдөөнийг арилгаж, системчлэл хийх нь чухал шаардлагатай.

3. ХУУЛИЙН ҮЙЛЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД

Мэдээлэл олж авах эрхийн тухай хуулиар ямар байгууллагууд хамгаалагдахыг тодорхойлох гол хоёр хандлага байдаг. **Нэгдэх нь** буюу нэлээд түгээмэл хандлага нь тийм байгууллагыг шууд тодорхойлоод, дараа нь эргэлзээтэй аливаа асуудлыг тохиолдол бүрээр нь авч үзэх явдал.

Хоёрт, зарим хуулинд тийм байгууллагуудыг жагсаалтаар дурдсан байдаг. Энэ нь ил тод байх эерэг талтай боловч бас дэндүү хязгаартай⁹ гэж үздэг байна.

Монгол Улсын хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хамааруулан жагсаалт гаргаж тодорхойлсон бөгөөд ингэснээр мэдээллийн ил тод байдал,

⁹ Тоби Менделл. “Мэдээллийн эрх чөлөө: Эрх зүйн харьцуулсан судалгаа. Парис.,2008 он

С.Батбуян. Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол Улсын хууль

мэдэх эрхийг хангах үүрэгтэй зарим байгууллага нь жагсаалтад багтахгүй байх, эсвэл шинээр үүссэн харилцаанд үндэслэн тодорхой байгууллага хамаарах үндэслэлтэй болох зэрэг тохиолдлууд гарч болно. Хууль батлагдан тогтвортой үйлчлэн, хэрэгжиж буй нөхцөлд тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулах нь төдийлэн боломжгүй тул жагсаалт гаргахын зэрэгцээ, ерөнхий нийтлэг шинжээрээ хамаарах субъектийг хуульчлан тодорхойлох нь оновчтой байна. Ерөнхий, нийтлэг шинжээр хамаарах байгууллагад нийтийн захиргааны чиг үүргийг гүйцэтгэх аливаа субъект нь нэмэгдэх боломжтой байж болох юм. Тухайлбал “ХБНГУ-ын эрх зүйн ойлголтоор аливаа хувь этгээдэд хуулиар эрх олгосон, үүрэг болгосон бол түүнийг захиргааны байгууллага гэж тодорхойлдог¹⁰” байна. Хуулийн дээрх жагсаалтаар бол гүйцэтгэх эрх мэдлийн нэг хэсэг болох нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээдүүд¹¹, үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллагууд¹², шашны байгууллагуудыг хамааруулаагүй байна.

Харин хууль тогтоох болон шүүх засаглалын тухайд “уг хуулийн хамрах хүрээнд оруулахгүй байх үндэслэл зарчмын хувьд байхгүй бөгөөд засаглалын тодорхой хэлбэрүүдээр хязгаарлах нь хүний эрхийнх нь хувьд мэдээлэл олж авах үзэл санаанд харшилна”¹³ гэдэг. Зарим улс орны хувьд, тухайлбал Швейцарь улсад “шүүх эрх мэдлийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлдэг хэсэг нь хамаарахаар байна. Үүнд шүүх эрх мэдлийн менежментийн үйл ажиллагаанд үндэслэсэн мэдээлэл буюу шүүхийн ажилтнууд, санхүү, бүтэц, зохион байгуулалтын болон захиргааны удирдлагын үйл ажиллагаа багтана. Харин шийдвэрлэгдсэн хэрэг болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиуд болон холбогдох хуулиудаар зохицуулдаг”¹⁴ байна. Энэ нь эрх мэдэл хуваарилах зарчим ёсоор шүүх эрх мэдэл нь хууль тогтоогчдын баталсан дүрмийн дор захирагдахгүйгээр мэдээллийн талаар өөрийн гэсэн эрхтэй байх шаардлага урган гарч болох ч ил тод байдлыг хангах үүрэг нь хэвээр байна.

Мөн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуулын байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад энэ хууль үйлчлэхгүй” гэж эдгээр байгууллагыг хуулийн үйлчлэлээс чөлөөлөхдөө үндэслэл заагаагүй байна. Тухайн хууль нь Төрийн нууцын тухай хуулиас бүрдэхээр заасан нөхцөлд эдгээр байгууллагыг чөлөөлөх нь дээрх байгууллагуудын нууцтай хамааралгүй бусад үйл ажиллагаа ил тод байхад хаалт болохоор заалт байна.

¹⁰ Creifelds. Rechts-Wörterbuch., 13.Au age. München. 1996. S-162. Дам ишлэв.

¹¹ Төрийн гүйцэтгэх байгууллагаас харьцангуй бие даасан захиргааны хуулийн этгээд буюу байгууллагууд: нэгдэл, албан газар, нийтийн эрх зүйн сан гэсэн гурван хэсэгт хуваагдана. П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ.,2008 он. 123 дахь тал.

¹² Төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг байгууллагууд.

¹³ Тоби Менделл. “Мэдээллийн эрх чөлөө: Эрх зүйн харьцуулсан судалгаа. Парис.,2008 он. 157 дахь тал.

¹⁴ https://www.ag.ch/media/kanton_aargau/dvi/dokumente_5/ges_1/organisation_8/idag/publikationen_2/leitfadenn_idag_ganz.pdf

Хувийн эрх зүйн хуулийн этгээдүүд нь хуулийн үйлчлэлд хамаарахгүй тухай. Эдгээр хуулийн этгээдүүдийн тухайд нийтийг хамарсан үйлчилгээ үзүүлдэг, шийдвэр үйл ажиллагаа нь нийтийн эрх ашгийг шууд хөндсөн байх боломжтой ч энэ тохиолдолд төрийн хяналт хэрэгжиж байхын зэрэгцээ хувийн эрх зүйн этгээдийн чөлөөт байдалд халдах үндэслэлгүй тул хуулийн үйлчлэлийн хүрээнд хамааруулахгүй.

4. НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙХ МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ

Ил тод байх ёстой мэдээлэл нь товчоор бол хуулийн үйлчлэлд багтсан байгууллагын мэдэлд байх, ямар хэлбэртэйгээсээ үл хамааран тус хуульд заасан хязгаарлалтад ороогүй бүхий л мэдээлэл байна. Ил болгох мэдээллийг ихэнхи улс орнууд албаны мэдээлэл гэж томъёолсон байдаг байна. Энэ нь тухайн мэдэх эрхийг хангахад тухай байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах нөхцлийг үүсгэхгүй байх, нөгөөтэйгүүр бүрэн гүйцэд боловсруулагдаагүй, тодорхой бус мэдээлэл нь мэдээллийг хүлээн авагч этгээдэд буруугаар ойлгогдох, нийгэмд аливаа сөрөг үр нөлөө үзүүлэх, төрийн бодлого алдагдуулах, шийдвэр гаргахад чөлөөтэй хэлэлцэж, санал бодлоо тусгах үйл ажиллагааг боогдуулахаас сэргийлэх зорилгоор үнэн зөв, бүрэн боловсруулагдсан мэдээлэл байх гэсэн агуулгыг илэрхийлэх зорилготой байна. Гэхдээ ийм хязгаарлалтыг мэдэх эрхийг бүрэн хүлээн зөвшөөрөгдөх байдлаар баталгаажуулсан нөхцөлд тодорхой бөгөөд зохистой хязгаарын тогтоож хуульчлах нь зүйтэй гэж үзнэ.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар¹⁵ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын мэдэлд байгаа бүх төрлийн мэдээлэл, тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл, үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг иргэн, хуулийн этгээд авах эрхтэй гэж заажээ. Тухайн байгууллагын мэдэлд байгаа гэдэг нь хууль тогтоомжоор тухайн байгууллагын хүлээсэн чиг үүрэгтэй холбоотойгоор байгаа болон байх ёстой мэдээлэлд хамаарахаар байна. Өөрөөр хэлбэл мэдэлд байгаа гэдэг нь зөвхөн гаргаж өгөх боломжтой гэх утгаар бус, тухайн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бүхий л төрлийн мэдээлэл байна. Тийм учраас шаардсан (байх ёстой) мэдээлэл байхгүй бол тухайн байгууллага цуглуулах, судалгаа шинжилгээ хийх зэргээр тухайн мэдээллийг бүрдүүлж, хүсэлт гаргагчид олгох ёстой. Тиймээс энэ хуулиар хамаарах байгууллагуудад энэ үүргийг хүлээлгэхээр тусгайлан заах нь зүйтэй.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг илтгэх мэдээлэл, эдгээрт аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхит бодисын хор хөнөөлийг тодорхойлсон зэрэг мэдээллийг нийтэд заавал нээлттэй байлгана гэж заасан боловч ил болгох шаардлагатай бусад төрлийн мэдээллээс онцгойлон үзэж байгаагийн хувьд нээлттэй байлгах тусгай журам тогтоох шаардлагатай. Гэтэл

¹⁵ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл.

С.Батбуян. Мэдэх эрх ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай Монгол Улсын хууль

хуульд заавал нээлттэй байлгах тухай зааснаас бус хэрэгжих процедурыг тогтоогоогүй нь тухайн заалтын ач холбогдлыг бууруулж байна. Улс орнуудын нийтлэг хандлагаар бол тусгай анхаарч үзэх салбарт Байгаль орчны талаархи мэдээлэл, Хүний эрхийн болон Улс төрийн оролцооны эрхийн талаархи мэдээлэл, Авлигатай тэмцэхтэй холбогдсон зэрэг мэдээллийг хамааруулсан байна¹⁶. Тиймээс тусгай салбарын мэдээллийг өргөтгөж, нээлттэй байлгана гэж тодорхойгүй заах бус хэвлэн нийтлэх үүргийг хүлээлгэж, нээлттэй байлгах журмыг нарийвчлан тогтоох шаардлагатай.

Тус хуулинд мэдээллийн ил тод байдал, түүний төрлүүдийг зааж, тухайн төрлийн мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар хэвлэн нийтлэхээр заажээ. Эдгээр мэдээллүүд нь ерөнхийдөө хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарах олон байгууллагуудаас зөвхөн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн мэдээллээр хязгаарлагдсан шинжтэй байна. Мэдэх эрх нь бусад эрх болон төр нээлттэй, ил тод байх зарчмын суурь болох тул хэвлэн нийтлэх мэдээллийн цар хүрээ нь илүү өргөн байх шаардлагатай. Түүнчлэн хэвлэн нийтлэх нь ардчилсан нийгэмд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хангахад чухал үр дүнтэй байдаг аж.

¹⁶ Тоби Менделл. Дурьдсан ном.